

Сумын Засаг даргын 2025 оны 03-р сарын 27-ны өдрийн 00/167 Тоот албан бичгийн 1-р хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2025 ОНЫ 1-Р УЛИРЛЫН МЭДЭЭ

2025.03.26

Шивээговь сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, иргэд олон нийттэй харилцах 70546204 дугаарын утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллаж байна.

2025 оны 1-р улирлын байдлаар сумын Засаг даргад хандаж ирүүлсэн 6 өргөдлийг хүлээн авч тус өргөдлүүдийг бүрэн шийдвэрлэсэн.

Засаг даргад хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн талаар авсан арга хэмжээ:

Газрын гэрчилгээ дахин олгож өгөх тухай 1 өргөдөлд өвөлжөө, хаваржааны газрын эзэмших эрхийн гэрчилгээг хаяж гээгдүүлсэн гэх нотлох баримт байхгүй байсан тул тус гэрчилгээг хаяж гээгдүүлсэн талаар сонинд зарлуулсан нотлох баримтыг бүрдүүлж ирүүлэх талаар хариуг өгсөн.

Хоршооны газар хүссэн 1 иргэний өргөдлийн дагуу сумын 2025 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусган ИТХ-ын хурлын 2025 оны эхний хагас жилийн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар хариуг өгсөн.

Эзэмшлээр авсан газрын газар эзэмших хугацааг сунгаж өгөх тухай 1 өргөдөл ирсний дагуу өргөдлийг судлан үзэхэд газар эзэмших хугацааг сунгахад бүрдүүлэх материалыг дутуу ирүүлсэн байсан тул бүрдлийг хангаж ирүүлэх талаар хариуг өгсөн.

Сумын нийгэмд үйлчилдэг Төрийн бус байгууллагаас Мак цемент ХХК-тай зам ашиглах, хамтран ажиллах гэрээнд малчид өөрсдийгөө төлөөлүүлэн Боржигины мөнхийн сахиус НҮТББ-ыг оролцуулах, мөн замын шороо тоосыг багасгуулах талаар хүсэлт ирсний дагуу Мак цемент ХХК-тай сумаас 2025 онд хамтран ажиллах Нийгмийн хариуцлагын гэрээний төслийг хэлэлцэх уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, сумын Засаг дарга, Мак цемент ХХК-ийн төлөөлөл, малчид болон ИТХ-ын төлөөлөгчдөөс оролцсон. Тус

уулзалтаар гэрээний төсөлд тусгах саналуудыг малчдаас авч, саналыг нэгтгэн гэрээний төсөлд тусгаж, тус компанид хүргүүлээд байна.

Мааньт 415 дугаар нээлттэй хорих ангид тодорхойлолт гаргуулах талаар 1 өргөдөл ирсний дагуу тус иргэнд сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн №01/120 тоот албан бичгээр тодорхойлолт гаргаж өгсөн.

Өвлийн хүлэмж хүссэн 1 иргэний өргөдлийг судалж үзэн өргөдлийн дагуу аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай холбогдоход аймгийн хэмжээнд тус асуудлыг шийдвэрлэх боломжгүй, өмнөх оны төсөвтөө тусган, хөрөнгийг шийдвэрлэсний дараа дэмжих боломжтой талаар хариуг өгсөн.

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ *Б. Ууганбаяр* Б.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ *Л. Бадамханд* Л.БАДАМХАНД



№	Гэмдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Газартай холбоотэй	3	50.00	
2	Өвлийн хүлэмж хүссэн	1	16.60	
3	Тодорхойлолт хүссэн	1	16.60	
4	Гэрээний сунгалтад нэмэлт оруулах хүсэлт	1	16.60	
	Нийт	6	99.80	